



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2016 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/352

Есөнбулаг сум

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн "Хөхморьт сумын наадмын талбай"-н ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	А.Алтанхуяг	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүдэд:	С.Содбаяр	(Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахлах дэслэгч)
	П.Хулан	(Аймгийн Төрийн архивын хэлтсийн дарга)
	Г.Даржаа	(Хөхморьт сумын Засаг дарга)
	Б.Батбаатар	(Хөхморьт сумын Засаг даргын Тамгын газрын дарга)
	Б.Батбилэг	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч)
	М.Энх-Орчлон	(Орон нутгийн өмчийн газрын Хууль, хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод хяналт шалгалтын мэргэжилтэн)
	Б.Цолмонбаатар	("Буяаннэмэх-Интер" ХХК-ийн захирал) (зохиогч)
Нарийн бичгийн дарга:	Г.Алтанбагана	("Виматик" ХХК-ийн захирал)
	Г.Лхагвабаатар	(Газрын харилцаа, барилга, хот

байгуулалтын газрын Инженерийн
дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн

2.Барилга байгууламжийн байнгын ашиглалтад оруулахдаа Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг мөрдөн гэрээнд тусгагдсан зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдэлтэй нийцүүлэн шалгаж, хүлээн авч, үр дүнг 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг комисс (А.Алтанхуяг)-т үүрэг болгосугай.

3.Холбогдох акт, баримт бичгийг үндэслэн орон нутгийн өмчид бүртгэхийг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг), барилга байгууламжийн урсгал зардлыг төсөвт тусгаж, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Хөхморьт сумын Засаг дарга (Г.Даржаа)-д тус тус даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2025 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн А/410, 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/430 дугаартай захирамжуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

